



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 4/33

Өмнөдэлгэр сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5, 48 дугаар зүйлийн 48.2, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Эгнээ гудамжны хотгор, хонхор засварлах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Гантулга

Нарийн бичгийн дарга: М.Уянга

Гишүүн: С.Батсуурь

А.Баянмөнх

Т.Одончимэг

Нягтлан бодогч

Архив, бичиг хэргийн ажилтан

Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн

Хэнтий багийн Засаг дарга

Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

2.Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд чанартай зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан, гэрээ байгуулах бэлтгэл ажлыг хангахыг үнэлгээний хорооны дарга (Б.Гантулга)-д даалгасугай.



Р.ЭНХТӨР

D:\disk\bichig hereg/ zahiramj

2325100060

